

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, САНГИЙН САЙД, ТӨРИЙН ӨМЧИЙН
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 09 дугаар
сарын 08 өдөр

Дугаар А/331/179/82 Улаанбаатар хот

Цэцэрлэгийн зориулалттай барилгын талбай
түрээслэх жишиг үнийн дээд хязгаар тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоолын 1.4 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлд цэцэрлэгийн зориулалтаар барилгын талбай түрээслэхэд 1 метр квадрат талбайн түрээслэх үнийн дээд хязгаарыг 45,000.0 төгрөгөөр тогтоосугай.

2. Энэхүү тушаалын нэгд заасан үнийн дээд хязгаарт багтаан түрээслүүлэгчтэй хэлэлцээ хийн холбогдох хууль, журмын хүрээнд гэрээ байгуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Нийслэлийн боловсролын газар, холбогдох төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/-т даалгасугай.

| | | |
|--|---|--|
| <p>БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД</p>  <p>Л.ЭНХ-АМГАЛАН</p> | <p>САНГИЙН САЙД</p>  <p>Б.ЖАВХЛАН</p> | <p>ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА</p>  <p>Б.ЦЭНГЭЛ</p> |
|--|---|--|